

# “ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2021 оны 02 дугаар сарын 23-ны өдөр

№ТУЗТ 01/2021

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Ноогдол ашиг хуваарилахгүй байх, Аудит хийлгэх, Хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг олгох, Тогтоолын заалтад өөрчлөлт оруулах, Хувьцаа худалдан авах, Сонирхолын зөрчилтэй хэлцэл баталгаажуулах, Их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 55 дугаар зүйл, 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.2, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.6, 76.1.8, 76.1.10, 76.1.12, 76.1.15, 76.1.16, 76.1.17, 76.1.18, 76.2 дахь хэсэг, 81 дүгээр зүйлийн 81.4.3, 81.4.4, 87 дугаар зүйлийн 87.1, 87.2 дахь хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1, 89.2 дахь хэсэг, 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “Эрдэнэс сольюшинс” ХК (“Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10.3, 9.10.4, 9.10.7, 10 дугаар зүйлийн 10.2.4, 10.2.5, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, “Ноогдол ашгийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэл тарааж олгох журам”-ын 1-р зүйлийн 1.1.2, 1.1.3, 1.1.4, 1.1.5 болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компани 2020 оны ноогдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Компани болон охин компани “Эрдэнэс рийл эстэйт” ХХК, компанийн худалдан авч буй “Эйс Ассошиэйтс ББСБ” ХХК, “Эрдэнэс коммодитийс трейдинг” ХХК-иудын 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн эцсийн байдлаарх жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх компаниар “Пи Кэй Эф Монголиа Аудит” ХХК-ийг сонгон, аудит хийх нийт зардлын хэмжээг 25 сая төгрөгөөр батласугай.
3. Компанийн тухай хууль болон “Эйс Ассошиэйтс ББСБ” ХХК-ийн дүрэмд заасан хувьцаа эзэмшигчийн эдлэх эрх, хүлээх үүргийг “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн нэрийн өмнөөс төлөөлж “Эйс Ассошиэйтс ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд эдлэх, нэмж хувьцаа гаргах, нэмж гаргах энгийн хувьцааны үнэ тогтоох, компани төлөөлж гэрээ хэлцэл хийх эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.
4. Компанийн ТУЗ-ын 2020 оны 03-р сарын 06-ны өдрийн ТУЗТ 03/2020 тоот тогтоолын 8-т заасан “Энэхүү тогтоолын 4 дэх хэсэг болон 6 дахь хэсэгт заасан компаниудын энгийн хувьцаа худалдан авах хугацаа 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хүчинтэй байх бөгөөд тус хугацааны дотор компаниудтай гэрээ, хэлцэл байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.” гэсэнийг “Энэхүү тогтоолын 4 дэх хэсэг болон 6 дахь хэсэгт заасан компаниудын энгийн хувьцаа худалдан авах хугацаа гэрээ байгуулсанаас хойш Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүртэл өдөр хүртэл хүчинтэй байх бөгөөд тус хугацааны дотор компаниудтай гэрээ, хэлцэл байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.” гэж өөрчилсүгэй.
5. Компани “Мөнгөн морь констракшн” ХХК-ийн 1 /нэг/ ширхэг нь 1/нэг/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 402,560,000.00 /дөрвөн зуун хоёр сая таван зуун жаран мянга/ ширхэг энгийн хувьцааны 85 /наян тав/ хувь буюу 342,176,000.00 /гурван зуун дөчин хоёр сая нэг зуун далан зургаан мянга/ ширхэг энгийн хувьцаа нэг бүрийг нь 1,17/нэг төгрөг арван долоон мөнгө/ төгрөгөөр буюу нийт 400,345,920.00 /дөрвөн зуун сая гурван зуун дөчин таван мянга есөн

зуун хорь/ төгрөгөөр худалдан авах гэрээ хийхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.

6. Компани болон “Мөнгөн морь констракшн” ХХК хооронд байгуулагдах Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, Эрх шилжүүлэх гэрээ болон тэдгээртэй нийцүүлэн гарах аливаа гэрээ, хэлцэл, баримт бичигт Компанийг төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.
7. Компанийн тухай хууль болон “Мөнгөн морь констракшн” ХХК-ийн дүрэмд заасан хувьцаа эзэмшигчийн эдлэх эрх, хүлээх үүргийг “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн нэрийн өмнөөс төлөөлж “Мөнгөн морь констракшн” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд эдлэх, нэмж хувьцаа гаргах, нэмж гаргах энгийн хувьцааны үнэ тогтоох, компани төлөөлж гэрээ хэлцэл хийх эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.
8. Компанийн 2020 онд Зээлийн гэрээгээр “Субашид тек” ХХК, иргэн “Б.Батсүрэн”, “Ц.Хуяг”, “Э.Цэндсүрэн”, “Т.Золбоо” нартай байгуулсан сонирхолын зөрчилтэй хэлцэлүүдийг зөвшөөрч, хийгдсэн гэрээнүүдийг баталгаажуулсугай.
9. Компанийн үйл ажиллагаанд зориулан 5 /тав/ тэрбум хүртэл төгрөгийн, сарын 3 /гурав/ хувь хүртэл хүүтэй, 5 /тав/ хүртэлх жилийн хугацаатай зээлийг бусдаас зээлийн болон бусад өр төлбөр хэлбэрээр бие даан татах эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.
10. Энэ тогтоолын 9-д заасны дагуу Компани сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах, нэгдмэл сонирхолтой этгээдээс зээл болон бусад өглөг үүсэгх нөхцөлд тухай бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлж байхыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Т.ЗОЛБОО/